



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 30

Арвайхээр


“Шатар” аймгийн хөтөлбөр батлах тухай

Аймгийн ИТХ-ын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.5.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд шатрын спортыг хөгжүүлэх “Шатар” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. “Шатар” хөтөлбөрийг сум, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд тусган ажиллахыг Сумдын засаг дарга нарт, шатрын спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэн ажиллахыг төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА  А.ИШДОРЖ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 01-р сарын 20-ны өдрийн
30-р тогтоолын Нэгдүгээр хавсралт

“ШАТАР” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Дэлхий ертөнц даяарчлагдан, нийгмийн харилцаанд мэдээллийн технологи, техникийн дэвшил нэвтрэх тусам хүний байгалиас заяагдмал төрөлх шинж саармагжиж амьдралын үнэт зүйлийн тухай ойлголт өөрчлөгдөн, уламжлалт ёс суртахууны үнэ цэнэ буурч байна. Иймээс хүүхэд, залуучууд, иргэдэд өөртөө болон ирээдүйдээ итгэх итгэлийг төлөвшүүлэх, амьдралын сайханд тэмүүлэх сэдэл төрүүлэх, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэн өөрийгөө хөгжүүлэх боломжийг тэгш олгох нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудал болоод байна.

Иймд хүүхэд, залуучууд, иргэдийг хөгжүүлэх нь дээрх асуудлыг шийдвэрлэх ойрын гарц, боломж гэж үзэн Өвөрхангай аймгийн хэмжээнд шатрын спортыг үр дүнтэй хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, түүгээр дамжуулан хүүхэд, залуучууд, гэр бүл, нийгэм, олон нийтэд эерэг хандлага, зөв үлгэрлэл төлөвшүүлэх нь зүйтэй юм.

“Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хүүхэд, залуучууд, иргэдэд шатар тоглох анхан шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэх, цаашид шатрын спортоор хичээллэх сонирхол, сэдэл тэмүүлэл бий болгон шатрын онолын ерөнхий мэдлэг, логик сэтгэлгээ, тэвчээр хатуужил, тууштай зан, аливаа асуудлыг олон талаас нь ургуулан бодож, ул суурьтай бодитой үнэлж, оновчтой шийдвэр гаргаж чаддаг зан чанарыг төлөвшүүлэх ач холбогдолтой юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 20 дугаар тогтоолоор “Шатрын спортыг аймгийн боловсролын бахархал болгон зарласугай” гэж заасан мөн аймгийн Засаг даргын “Бүтээлч Өвөрхангай-2020” үйл ажиллагааны хөтөлбөр зэргийн хүрээнд тус хөтөлбөр боловсруулагдсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Шатрын спортоор дамжуулан хүүхэд, залуучууд, иргэдийг өөртөө болон ирээдүйдээ итгэх итгэлтэй, аливаа асуудлыг олон талаас нь харж, оновчтой шийдвэр гаргах чадвартай болгон төлөвшүүлэх нь энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго юм.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Шатрын спортыг хөгжүүлэх нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, багш дасгалжуулагчдыг чадваржуулах, урамшуулан дэмжих боломжийг бүрдүүлэх,

3.2. Шатрын дугуйлан хичээллүүлэх, кабинет, булан байгуулах үйл ажиллагааг аймаг, сум, орон нутгийн зүгээс дэмжих, хүүхэд, залуучууд, иргэдэд шатрын анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтын хөтөлбөрөөр дугуйлан хичээллүүлэх, шатрын спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, хүрээг өргөжүүлэх,

3.3. Шатрын спортыг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах, мэдээлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. “Шатрын спортыг хөгжүүлэх нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, багш дасгалжуулагчдыг чадваржуулах, урамшуулан дэмжих боломжийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.1. Сум бүр шатрын клуб, холбоотой болж, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,

4.1.2. Хөтөлбөрийн хүрээнд байгууллага бүр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө шатрын спортыг байгууллагын хэмжээнд хөгжүүлэх, дэмжих, хамтарч ажиллах, сурталчлан түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг тусган хэрэгжүүлж ажиллах,

4.1.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль бүр шатрын сургалтыг сум, орон нутаг, байгууллагын онцлогт тулгуурлан хичээлээс гадуурх үйл ажиллагаа, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, сургуулийн мэдлийн цагаар дамжуулан зохион байгуулж ажиллах,

4.1.4. Шатрын сургагч багш нарыг шинээр болон давтан бэлтгэх, тэдэнд зориулсан сургалтуудыг холбогдох байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулах,

4.1.5. Хүүхэд хүүхдээсээ суралцдаг арга зүйг хэрэгжүүлэн үе тэнгийн шатрын сургагч багш бэлтгэн хамтран ажиллах,

4.1.6. Сум бүр хүүхдийн парк, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн талбайд, шатрын хөлөг бүхий орчин бий болгох, байгууллага бүр шатрын танхим, кабинет, булан байгуулан тохижуулж, ажиллуулах

4.1.7. Төрийн болон төрийн бус байгууллага, үйлчилгээний байгууллагууд амрах байр, хүлээлгийн танхим, олон нийтэд үйлчлэх заал болон бусад боломжит орчиндоо шатар байрлуулан хүүхэд, залуучууд, иргэдийн тоглох боломж нөхцөлөөр хангах,

4.1.8. Сум, орон нутагт ажиллаж байгаа шатрын багш, дасгалжуулагч нарыг урамшууллын асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх, шатрын спортын клуб, дугуйланг бие даан хичээллүүлдэг багш, дасгалжуулагчдыг дэмжин ажиллах,

4.1.9. Шатрын спортыг өрх, гэр бүл, байгууллагын болон иргэд, олон нийт, сум орон нутгийн хэмжээнд хөгжүүлж чадсан иргэн, багш, дасгалжуулагч, аж ахуйн нэгж байгууллагуудыг алдаршуулж, дэмжин ажиллах ажиллах,

4.2. “Шатрын дугуйлан хичээллүүлэх, кабинет, булан байгуулах үйл ажиллагааг аймаг, сум, орон нутгийн зүгээс дэмжих, хүүхэд, залуучууд, иргэдэд шатрын анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтын хөтөлбөрөөр дугуйлан хичээллүүлэх, шатрын спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, хүрээг өргөжүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

4.2.1. Сум, орон нутагт шатрын дугуйлан хичээллүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн байгууллагын санхүүжилтээр шийдвэрлэх ажлыг зохион байгуулах,

4.2.2. Хүүхэд, залуучууд, иргэдэд шатрын анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтын хөтөлбөрөөр дугуйлан хичээллүүлэх,

4.2.3. Шатрын спортыг сонирхдог, дэмждэг, шатарт элэгтэй багш сурган хүмүүжүүлэгч, олны танил алдартай хүмүүс, иргэдээр удирдуулсан дугуйлан хичээллүүлэхийг дэмжин ажиллах,

4.2.4. Байгууллагууд шатрын спортыг хөгжүүлэх зорилгоор шатрын хэрэглэгдэхүүн, компьютер, програм хангамжтай болох, мөн “Шатар тоглох өдөр”-тэй болж, ажилтан бүрийг шатар тоглож сурах боломжийг бүрдүүлэх,

4.2.5. Сумын удирдлагууд шатрын спортыг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих зорилгоор тогтсон нэг өдрийг “Шатрын тэмдэглэлт өдөр” болгон зарлаж, олон нийтийн дунд уралдаан тэмцээн бусад үйл ажиллагааг зохион байгуулах,

4.2.6. Шатрын спортын аймаг, сумын аварга шалгаруулах тэмцээн, шатрын алдартнуудын нэрэмжит тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах, шатрын зүтгэлтнүүдийг алдаршуулах үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллах

4.2.7. Сум, байгууллага бүр аливаа уралдаан тэмцээн зохион байгуулахдаа шатрын спортын төрлийг оролцуулдаг байх,

4.2.8. Бүсийн болон улсын чанартай уралдаан, тэмцээнийг аймагт, аймгийн чанартай уралдаан, тэмцээнийг суманд зохион байгуулах санал, санаачилга гаргах ажиллах,

4.2.9. Аймаг, сум, багууд “Шатарчин гэр бүл”, “Шатарчин баг”-ийг шалгаруулан тэднийг алдаршуулах, урамшуулан дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах,

4.2.10. Өндөр зэрэгтэй шатрын багш, дасгалжуулагч, тамирчин, сурагч багачуудыг дэмжих, тэдний олон улс, тив, дэлхийн болон улс, бүс, аймаг, сумын тэмцээнд оролцоход байгууллага, аж ахуйн нэгж, иргэд олон нийт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэднийг спортын зэрэг цол авах, шагналд нэр дэвшүүлэхэд аймаг, сум, орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх,

4.2.11. Айл, өрх бүр гэртээ шатартай болж гэр бүлээрээ шатарчин болох хөдөлгөөн өрнүүлэх,

4.3. “Шатрын спортыг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах, мэдээлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

4.3.1. Сум, орон нутаг, байгууллага, аж ахуйн нэгж, шатрын холбоод “Шатар” хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээллийн самбар, цахим хуудас, олон нийтийн сүлжээ, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан улирал бүр сум, аймаг, улсын хэмжээнд сурталчлах, мэдээлэх,

4.3.2. “Шатар” хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, арга туршлага, амжилт бүтээл, шатрын сорилго, бодлого зэргийг мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах боломж бүхий нээлттэй цахим сүлжээ бий болгох, үйл ажиллагааг тогтмолжуулах,

4.3.3. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байгаа уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон сум, баг, байгууллага, иргэдийг олон нийтийн сүлжээ, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулан дэмжих,

4.3.4. Орон нутгаас төрөн гарсан өндөр зэрэгтэй шатрын багш, дасгалжуулагч, тамирчдын олон улс, тив, дэлхийн болон улс, бүс, аймаг, сумын тэмцээнд үзүүлсэн амжилтыг сурталчлах, нэвтрүүлэг бэлтгэн нийтэд хүргэх,

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

Энэхүү хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжинэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөр нь улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив тусламжаас бүрдэнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур

Д/д	Шалгуур үзүүлэлт	Гарааны түвшин /2017 он/	Хүрэх түвшин /2020 он/
1	Сум бүр шатрын холбоотой болсон байна.	5 сум	19 сум
2	Сум бүрт тогтмол үйл ажиллагаа явуулдаг шатрын клуб, дугуйлантай болсон байна.	5 сум	19 сум
2	Аймгийн нийт төсөвт 180 байгууллагуудын 50-аас доошгүй хувь нь шатрын танхим, булантай болсон байна.	23 байгууллага	90 байгууллага
3	Шинээр байгуулсан гаднах талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн тоо	0	19 сум
4	Шатрын дунд шатны сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа хүүхэд, залуучууд, иргэдийн тоо	2200	4400
5	Шатрын гүнзгий шатны сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа хүүхэд, залуучууд, иргэдийн тоо	1034	2000
6	Шатрын клуб, дугуйлан, сургалтад хамрагдсан хүүхэд, залуучууд, иргэдийн тоо	7005	16000
7	Шатрын спортын зэрэгтэй тамирчдын тоо	36	80
8	Аймаг, улс, олон улсын уралдаан, тэмцээний амжилт	Шатрын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилтаар	

--ооо--